

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Дэмд-Од ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2025/017/НА-СТА-ОНӨҮГ**

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2025 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Алтанцэцэг Утас: 8000-7121 Цахим хаяг: tolinetugen@gmail.com Толин этүгэн аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Б.Отгон-Өлзий Утас: 99844655 Цахим хаяг: otgon1118@yahoo.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.03.14 № АБЗ
танай _____ -ны № _____ -т

ДЭМД ОД ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Б.ЦОГНЭМЭХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дэмд-Од ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) -ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 211,930.0 мянган төгрөгийн авто кран, Сэврэй сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар 82,505.5 мянган төгрөгийн трактор нийлүүлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 791.6 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар бизнес төлөвлөгөөг батлуулан гүйцэтгэлээр 8,711.2 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн

462502057C

тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБЯАР

Өмнөговь аймгийн Дэмд Од ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
хураангуй тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө	168,242,761.09	158,999,128.19
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	128,324,506.90	133,054,393.79
1.1.2	Дансны авлага	1,684,520.92	913,606.29
1.1.6	Бараа материал	37,192,317.09	21,635,465.22
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,041,416.18	3,395,662.89
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	168,242,761.09	158,999,128.19
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	5,862,804,876.36	5,942,991,025.13
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,842,165,209.65	5,922,593,025.13
1.2.2	Биет бус хөрөнгө	20,639,666.71	20,398,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,862,804,876.36	5,942,991,025.13
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,031,047,637.45	6,101,990,153.32
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр	5,270,474,126.80	5,319,019,338.53
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	3,455,348.51	-
2.1.1.3	Татварын өр	3,455,348.51	
2.1.2.1	Бусад урт хугацаат өглөг	5,267,018,778.29	5,319,019,338.53
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,267,018,778.29	5,319,019,338.53
2.2	Өр төлбөрийн нийт дүн	5,270,474,126.80	5,319,019,338.53
2.3	Эздийн өмч	760,573,510.65	782,970,814.79
2.3.1	Өмч: - төрийн	1,178,704,122.04	1,178,704,122.04
	- хувийн	20,398,000.00	20,398,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	66,698,098.00	66,698,098.00
2.3.9	Хуримтлагдсан (алдагдал)	(505,226,709.39)	(482,829,405.25)
2.3.11	Эздийн өмчийн дүн	760,573,510.65	782,970,814.79
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,031,047,637.45	6,101,990,153.32

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	356,397,125.94	505,963,070.17
2	Борлуулалтын өртөг	644,862,055.39	732,622,016.74
3	Нийт ашиг	(288,464,929.45)	(226,658,946.57)
4	Бусад орлого	395,466,582.45	347,344,652.77
5	Ерөнхий ба удирдлагын зардал	60,808,185.58	110,770,868.91
6	Бусад зардал	7,432,669.78	235,691.57
7	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	38,760,797.64	9,679,145.72
8	Орлогын татварын зардал	3,876,079.76	967,914.57
9	Татварын дараах ашиг (алдагдал)	34,884,717.88	8,711,231.15
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	34,884,717.88	8,711,231.15
11	Орлогын нийт дүн		
12	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

Өмнөговь аймгийн Дэмд Од ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,199,102,122.04	66,698,098.00	(505,226,709.39)	760,573,510.65
Залруулсан үлдэгдэл	1,199,102,122.04	66,698,098.00	(505,226,709.39)	760,573,510.65
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	8,711,231.15	8,711,231.15
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	13,686,072.99	13,686,072.99
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,199,102,122.04	66,698,098.00	(482,829,405.25)	782,970,814.79

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	398,419,476.32	598,176,858.43
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	398,419,476.32	598,176,858.43
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	332,619,328.88	593,446,971.54
1.2.1	Ажиллагчдад төлсөн	126,344,563.00	197,686,802.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	43,694,282.57	59,756,428.06
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	39,671,103.93	159,369,031.57
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	32,525,106.86	31,539,841.43
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	17,496,460.00	15,276,252.00
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	72,148,062.52	121,143,954.66
1.2.7	Бусад мөнгөн зарлага	739,750.00	8,674,661.82
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	65,800,147.44	4,729,886.89
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4.1	Валютын ханшийн зөрүү	-	-
4.2	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	65,800,147.44	4,729,886.89
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	66,160,070.39	128,324,506.90
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	128,324,506.90	133,054,393.79

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ
Нийт орлого		749,501,167.30	853,307,722.94	(103,806,555.64)
1	Борлуулалтын орлого	420,311,135.30	428,545,356.71	(8,234,221.41)
2	Бусад үйл ажиллагааны орлого	41,160,000.00	77,417,713.46	(36,257,713.46)
3	Үндсэн хөрөнгийн элэгдэлийн орлого	288,030,032.00	347,344,652.77	(59,314,620.77)
Нийт зардал		748,621,627.00	843,628,577.00	(95,006,950.00)
1	Цалин	228,337,992.00	244,434,563.00	(16,096,571.00)
2	ЭМНДШ	34,387,909.00	32,563,833.06	1,824,075.94
3	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	2,500,000.00	1,320,520.00	1,179,480.00
4	Албан томилот	1,540,000.00	884,000.00	656,000.00
5	Тээврийн зардал	43,200,000.00	46,839,638.04	(3,639,638.04)
6	Түүхий эд материалын зардал	36,397,821.00	15,856,821.06	20,540,999.94
7	Элэгдлийн зардал	264,237,075.00	372,521,589.47	(108,284,514.47)
8	Шуудан холбооны зардал	1,920,000.00	363,636.33	1,556,363.67
9	Шатахууны зардал	16,256,000.00	14,302,947.60	1,953,052.40
10	Бичиг хэргийн зардал	2,396,000.00	1,719,597.35	676,402.65
11	Цахилгааны зардал	38,999,869.74	28,672,583.11	10,327,286.63
12	Төлбөр хураамж	6,574,000.00	1,831,872.69	4,742,127.31
13	Тэтгэмжийн зардал	3,500,000.00		3,500,000.00
14	Сургалт семанар	27,000,000.00	9,504,980.00	17,495,020.00
15	Хангамжийн материал сэлбэг запас	35,150,000.00	66,821,995.54	(31,671,995.54)
16	Хөдөлмөр хамгаалалын зардал	6,224,960.00	5,989,999.97	234,960.03
17	Үйл ажилгааны ашиг	879,540.59	9,679,145.72	(8,799,605.13)
18	Үйл ажилгааны бус зардал			-
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал/		879,540.59	9,679,145.72	(8,799,605.13)
ААНОАТ-ын зардал		87,954.06	967,914.57	(879,960.51)
Татварын дараах ашиг /алдагдал/		791,586.53	8,711,231.15	(7,919,644.62)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 35,097.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 3 зөвлөмж өгч ажилласан.

3.1 Зөвлөмж

Илрүүлэлт: 1

Тайлант оны батлагдсан зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй байхад 4,820.1 мянган төгрөгөөр 3 дугуйтай мотоциклийг худалдан авч, сэлбэг хэрэгслийн дансанд бүртгэсэн зөрчил байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.9.хариуцлагатай байх, НББ-ийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх; батламж мэдэгдлийг хэрэгжүүлж ажиллах.

Илрүүлэлт: 2

Захирлын тушаал шийдвэр, эрх зүйн үндэслэлгүйгээр нягтлан бодогч Б.Амарбаатарт ШУТИС-ЭХС-ийн сургалтын төлбөрт 3,956.4 мянган төгрөг, ШУТИС-д дүйцүүлэхийн төлбөрт 754.9 мянган төгрөг, нийт 4,711.3 мянган төгрөгийг шилжүүлсэн зөрчил байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.9.хариуцлагатай байх заалтыг үндэслэл төлбөрийн акт тогтоож байна.

Илрүүлэлт: 3

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Өмнөговь аймгийн Дэмд Од ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
хураангуй тайлан

Тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны түүхий эд материал болох нүүрсийг худалдан авах ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулаагүй, 3 иргэнтэй гэрээ байгуулж шууд худалдан авалт хийсэн зөрчил байна.

Өгсөн зөвлөмж:

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно, 18.1.Захиалагч энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана, ЗГ-ын 2024.01.03-ний өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан “худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” тогтоолыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант оны батлагдсан зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй байхад 4,820.1 мянган төгрөгөөр 3 дугуйтай мотоциклийг худалдан авч, сэлбэг хэрэгслийн дансанд бүртгэсэн зөрчил байна.	1	4,820.1					1	4,820.1		
Захирлын тушаал шийдвэр, эрх зүйн үндэслэлгүйгээр нягтлан бодогч Б.Амарбаатарт ШУТИС-ЭХС-ийн сургалтын төлбөрт 3,956.4 мянган төгрөг, ШУТИС-д дүйцүүлэхийн төлбөрт 754.9 мянган төгрөг, нийт 4,711.3 мянган төгрөгийг шилжүүлсэн зөрчил байна.	1	4,711.3					1	4,711.3		
Тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны түүхий эд материал болох нүүрсийг 3 иргэнтэй гэрээ байгуулж шууд худалдан авалт хийсэн зөрчил байна.	1	25,565.8					1	25,565.8		
Нийт	3	35,097.2					3	35,097.2	-	-